



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

Автотээврийн болон өөрөө явагч
Хэрэгслийн албан татвар, агаарын
бохирдлын төлбөр, авто зам ашигласны
төлбөр хураах талаар авах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Нийслэлийн 2021 оны төсөв батлах тухай" 02/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр /цаашид албан татвар, төлбөр гэх/ хураах, тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлд бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэн, албан татвар, төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Т.Гантөмөр/-т даалгасугай.

3.Дүүргийн Засаг дарга нар салбар ажлын хэсэг байгуулж дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай.

3.1.Албан татвар, төлбөр хураах ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулж, тухайн нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татварт бүрэн хамруулж, татварт хамрагдалтын түвшинг өмнөх жилээс нэмэгдүүлэх;

3.2.Албан татвар, төлбөр хураах ажлыг Засаг даргын дэргэдэх хэлтэс болон харьяа байгууллагатай хамтран /Тээврийн цагдаагийн алба, Замын цагдаагийн хэлтэс, хороод, Автотээврийн үндэсний төвийн салбар, банкны байгууллага түүнчлэн холбогдох бусад байгууллага/ Татварын хэлтэс зохион байгуулж ажиллах;

3.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэх, Нийслэлийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;

3.4.Албан татвар, төлбөр хураахтай холбогдсон мэдээлэл, тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ "smartcar.mn", татварын удирдлагын нэгдсэн "e-tax.mta.mn,

i-tax.mta.mn” систем, “и-баримт” гар утасны аппликэйшн, “гэрэгэ” киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөрөө төлөх талаар заавар, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээх, сурталчлах;

4. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

4.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд автотээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөрийн тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх журам”-ын 3.4-т заасны дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж, тухайн сардаа албан татвар, төлбөр төлөөгүй автотээврийн хэрэгсэлд хяналт тавьж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн татварын газар /Б.Цогтнарэн/, Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газар /Б.Эрдэнэбат/-т;

4.2. Тухайн сард албан татвар, төлбөрөө төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй замын хөдөлгөөнд оролцож байгаа автотээврийн хэрэгслийг хяналтын камерын тусламжтайгаар илрүүлж, хууль тогтоомжийн дагуу торгуулийн мэдэгдэх хуудас хүргүүлэн, холбогдох газруудыг мэдээллээр хангаж хамтран ажиллахыг Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ /Д.Одбаяр/, Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газар /Б.Эрдэнэбат/-т;

4.3. Нийслэлийн төр, захиргааны болон нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/, Нийслэлийн татварын газар /Б.Цогтнарэн/, Нийтийн тээврийн үйлчилгээний газар /Ч.Сайханбаяр /-т;

4.4. Албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг 2021 оны Нийслэлийн замын сангийн төлөвлөгөөнд батлагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/, тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ “smartcar.mn” систем, Татварын удирдлагын нэгдсэн “e-tax.mta.mn, i-tax.mta.mn” систем, “и-баримт” гар утасны аппликэйшн, гэрэгэ киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөр төлөх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэлтэй харилцах хэлтэс /Б.Батманлай /-т;

4.5. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах, төвлөрсөн үйлчилгээний цэгүүдийг тогтмол ажиллуулж байхыг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/, Нийслэлийн татварын газар /Б.Цогтнарэн/-т;

5. Нийслэлд албан татвар, төлбөр төлөөгүй замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг (RFID) технологийн дэвшил ашиглан олж илрүүлэх, хяналт тавих систем хөгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /О.Чинзориг/, Нийслэлийн Татварын газар /Б.Цогтнарэн/, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ /Д.Одбаяр/-т тус тус үүрэг болгосугай.


6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед төрийн байгууллага, хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг албан татвар, төлбөр төлсөн эсэхийг үндэслэн олгохыг Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар /С.Энхтөр/, Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /О.Чинзориг/, Нийслэлийн Татварын газар /Б.Цогтнарэн/-т үүрэг болгосугай.

7. Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягийн бүртгэлийг шинэчлэх, нийслэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн шилжих хөдөлгөөн, хасалтыг албан татвар, төлбөр

төлснийг үндэслэн шилжүүлж, техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн яамны харьяа Автотээврийн үндэсний төв /Б.Гүрсоронзон/-д зөвлөсүгэй.


8.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/15 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 09-ны өдрийн
1175 дугаар захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР, АГААРЫН БОХИРДЛЫН
ТӨЛБӨР, АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
дарга:

Улаанбаатар хотын Ерөнхий менежер
бөгөөд Захирагчийн ажлын албаны
дарга Т.Гантөмөр

Гишүүд:

Нийслэлийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга Н.Наранбаатар

Нийслэлийн Засаг даргын Тамгын
газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах
хэлтсийн дарга Б.Батманлай

Замын цагдаагийн албаны
Нийслэлийн замын хөдөлгөөний
хяналтын газрын дарга, Цагдаагийн
хурандаа Б.Эрдэнэбат

Авто тээврийн үндэсний төвийн дэд
захирал /зөвшилцсөнөөр/ Х.Баярхүү

Нийслэлийн Татварын газрын дарга
Б.Цогтнаран

Нийслэлийн Авто замын хөгжлийн
газрын дарга Г.Баярсайхан

Нийтийн тээврийн үйлчилгээний
газрын дарга Ч.Сайханбаяр

Нийслэлийн мэдээллийн технологийн
газрын дарга О.Чинзориг

Дүүргийн Засаг даргын орлогч нар

Нарийн бичгийн
дарга:

Нийслэлийн татварын газрын Дэд
дарга М.Болдбаатар